





ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт




ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: 5.1%,
Инфляци: 2021 онд: 8.2%,
Урсгал тэнцэл: 2021 онд: -8.3%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: 6%
Инфляци: 2021 онд: 5.5%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: -13.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 5-р сарын байдлаар (866.3) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 15.9 хувиар өссөн бол, зарлага 25.4 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 866.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 45.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 0.33 төгрөгөөр буурчээ.

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 52.3 төгрөг буюу 1.9 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.33 төгрөгөөр буурч 2849.57 төгрөг болов. 4-р сард гадаад валютын нөөц 4.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар өсч, оны эхнээс 7.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 6.2%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 5-р сарын байдлаар өмнөх сараас 0.7 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар, оны эхнээс 6.3 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 5 дугаар сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 722.4 сая.ам долларын ашигтай гарав.

2021 оны тавдугаар сард нийт барааны эргэлт 5925.6 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 48 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 65.6 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 722.4 сая ам.долларын ашигтай гарав.



5-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 5-р сард өмнөх сараас 3.4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар тус тус өсч 18.2 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2024 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11% байна.

Арилжааны банкнуудаас иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 4 дүгээр сарын эцэст 8.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 92.2 (1.0%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 191.8 (2.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 46.5 хувийг бизнес эрхлэх зээл, 30.1 хувийг цалингийн зээл, 8.1 хувийг малчны зээл, 6.4 хувийг хадгаламж, данс барьцаалсан зээл, 2.5 хувийг автомашины зээл, 2.3 хувийг картын зээл, 1.5 хувийг тэтгэврийн зээл, 0.6 хувийг өрхийн хэрэглээний зээл, 2.0 хувийг бусад зээл тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

БАНКУУДАД 275 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОВ

- Монголбанк энэ оны 2 дугаар улирлын репо арилжааг зохион байгуулж, 350 тэрбум хүртэл төгрөгийн репо арилжаа зарлан, 6 банкнаас 275 тэрбум төгрөгийн репо санхүүжилт авах санал ирүүлснийг биелүүлэв. Энэ санхүүжилтээр банкууд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспорт, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, хоёр зуу болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдэд зээл олгох юм. Репо санхүүжилтийн зээлийг Хаан, Худалдаа хөгжлийн, Голомт, Төрийн, Хас, Капитрон, Тээвэр хөгжлийн, Кредит, Богд банкнаас авах боломжтой.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО 8.2 ХУВИАР НЭМЭГДЭВ

- Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 4 сарын байдлаар 813.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 61.6 (8.2 хувь) тэрбум, нийт зарлага 836.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 61.4 (7.9 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 109.3 (26.4 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин нийгмийн даатгалын сангийн зарлага өсөхөд нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардал 60.9 (7.9 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 5-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 5-р сар 2021 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn.